*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын*
*2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

АРВАЙХЭЭР СУМЫН ХҮЙС ТОЛГОЙН 11 ДҮГЭЭР БАГИЙН ЗАСАГ ДАРГА Б.ЗОЛБООГИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин, биелэлт | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.“Дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах”** | | | | | | | |
| 1. | **1.1.** Тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлэх. | Хяналтад авсан заалтын хэрэгжилтийн хувиар | 90 | 90 | Хууль тогтоомж лавламжийн санд нийт 20 эрх зүйн акт, үүнээс шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо 3, эрх зүйн лавлагаа мэдээлэл өгсөн иргэдийн тоо 215, боловсруулсан гарын авлага 2 хийсэн байна. Эрх зүйн мэдээлэл лавлагааны дийлэнх хувийг Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Иргэний хууль, цахим шилжилттэй холбоотой иргэдийн цахим ур чадвар хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлийн зөвлөгөө мэдээлэл бусад хууль тогтоомжууд эзэлж байна. | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| | **1.2.** “Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөрийг сурталчлах. Улаанбаатар, **Эрдэнэт, Дархан болон бусад хотуудаас шилжин ирж байгаа өрхийн хүүхдүүдийг хамран сурах тойргийн ЕБС, СӨБ-д хамруулах.** | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | - | 1 | Нээлттэй Өвөрхангай хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар, Эрдэнэт, Баянхонгор зэрэг аймаг, нийслэлээс шилжин ирсэн 25 өрхийн сургууль, цэцэрлэгийн насны нийт 48 хүүхдийг сургууль, цэцэрлэгт бүрэн хамруулсан. | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| | | Хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар | 90 | 90 | Тайлант хугацаанд Улаанбаатар, Эрдэнэт, Баянхонгор зэрэг аймаг, нийслэлээс 30 өрхийн 75 иргэн тус багт шилжин ирж, суурьшсан байна. | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| | **1.3.** “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” | **Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар** | - | 50 | **Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтот жилийн ажлын төлөвлөгөөг 11 арга хэмжээний хүрээнд боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж** | **2024.01.01 2024.11.25** | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **зорилтод жилийн** хүрээнд төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх. | | | | **байна. Зорилтод жилийн төлөвлөгөөний хүрээнд** иргэдийн цахим ур чадварыг хөгжүүлэх анхан шатны сургалтанд хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдээд **байна. 2023 онд 42 иргэн, 2024 онд 86 иргэн цахимаар цэргийн бүртгэлд бүртгүүлсэн Урд оноос 2 дахин өссөн, ОНХСХөрөнгөөр хийж гүйцэтгэх ажлын санал 2023 онд 125 иргэн, 2024 онд 177 иргэн цахимаар** саналаа өгсөн байна. Урд оноос 41.6 хувиар өссөн дүнтэй байна. Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн хүрээнд цэргийн насны залууст **Цахим орчин дахь аюулгүй байдал сургалтыг Цагдаагийн газар, Арвайхээр сумын гэмт хэргээс** урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран зохион байгууллаа. "Цахимын зөв хэрэглээ" сургалт зохион **байгуулж 54 иргэн хамрагдсан. Хүйс толгойн 11 дүгээр багийн Хамтарсан баг "Тантай хамт" явуулын үйлчилгээг 2 удаагийн давтамжтай зохион байгуулж** давхардсан тоогоор 83 иргэнд хүрч үйлчилсэн. | | |
| | **1.4.** "Тэр бум мод" **үндэсний** хөдөлгөөнийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, **хэрэгжилтийг** хანган ажиллах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | - | 2 | **Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд багийн иргэдийг ногоон байгууламж нэмэгдүүлэх, байрны** гадаа болон айл өрх бүр хашаандаа мод тарихыг **уриалан Хотын захирагчийн албанаас гаргаж байгаа шторк цахим сүлжээгээр дамжуулан мэдээлэл хийж** ажиллаж байна. Намрын мод тариалалтын ажлыг багтаа зохион байгуулж, 24-н өрхөд үнэгүй мод тарааж, тариулан ургалт усалгаан дээр хяналт тавин **ажиллаж байна.** | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| | | Сургалт, мэдээлэлд хамрагдсан **өрхийн тоогоор** | 10 | 10 | Хотын захирагчийн албатай хамтран "Модоо хэрхэн тарих вэ" сургалтыг 36-н иргэнд хийж мөн гарын авлага, боршуур бэлтгэн багийн 210 иргэнд тарааж, **зөвлөгөө мэдээлэл өгсөн.** | 2024.01.01 2024.11.25 | 70 |
| | **1.5. Багийн хэмжээнд улирал бүр нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж нэгдсэн хог тээврийн хуваарийн дагуу хог ачилтад хяналт тавих** | **Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор** | **4** | **2** | **Бүх нийтийн их цэвэрлэгээг 4 удаа зохион байгуулж, цэвэрлэгээнд давхардсан тоогоор нийт 360 иргэн хамрагдаж, 34 тонн хогийг хогийн нэгдсэн цэгт төвлөрүүлж ажилласан. Мөн хог ачилт, тээвэрлэлтийн хуваарьт хяналт тавьж, иргэдээс ирсэн гомдол, саналыг тухай бүрд шийдвэрлэж ажиллаж байна.** | **2024.01.01 2024.11.25** | **100** |
| | **1.6.** Агаар, орчны | Зохион | 2 | 2 | Агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр багийн | 2024.01.01 | 100 |

181

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлыг дэмжиж, хамтран ажиллах. | байгуулсан арга хэмжээний тоогоор | | | шахмал түлш хэрэглэж буй 30 өрхөд угаар мэдрэгч суурилуулсан. Агаарын бохирдолын эх үүсвэрийн судалгааг шинэчилэн нэмж байшинтай 107 өрх, гэртэй 408 өрх нийт 515 өрхийн агаар бохирдуулагч эх үүсвэрийн 3-15 квт хүчин чадалтай зуух судалгааг программд заагдсан асуулгын дагуу 100 хувь шивж оруулсан. | 2024.11.25 | |
| | | Сайжруулсан шахмал түлшийг хэрэглээнд нэвтрүүлсэн өрхийн хувиар | 5 | - | Одоогоор сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэгээгүй байна. | 2024.01.01 2024.11.25 | - |
| | **1.7.** Малчдын болон, тариаланчид чадавхжуулах ажил зохион байгуулах, | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 00 | 1 | Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор МУЗГ-ын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг талаарх мэдээллийг малчдад сурталчилж, хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэх заавар, бүрдүүлэх материалыг хагас жилийн мал тооллогоор 75 өрхөд тарааж, Бодлогын хүрээнд хөдөө орон нутагт томилогдсон ажилтантай хамтарч 43 малчин өрхөөр явж мэдээлэл өгч ажилласан. Багийн иргэдээс 3 хоршоо шинээр байгуулагдсан. | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| | **1.8.** Өвөлжилтийн бэлтгэл хангуулах төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 100 | 100 | Өвөлжилтийн бэлтгэл хангах 11 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулж сумын Засаг даргын орлогч Ц.Эрдэнэсүрэнгээр батлуулан биелэлтийг хангаж ажиллаа. | 2024.08.01 2024.11.25 | - |
| | **1.9.** Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон бичил бизнес эрхлэгчдийг төсөл хөтөлбөрийн сургалтад хамруулах, зуулчлах. | Төсөл хөтөлбөрт зуулчилж, сургалтад хамруулсан хувиар | 3 | 5 | Малжуулах төсөлд хамруулахаар журам шаардлага хангасан 1 өрхийн материалыг бүрдүүлэн, ХХҮГ-т хүргүүлж, төсөл хөтөлбөрт хамруулсан мөн өрхийн ногоо тариалах төсөл хөтөлбөрт 1 өрхийг хамруулсан.<br><br>Нийтийг хамарсан ажилд 4, улирлын чанартай ажилд 3, нийт 7 иргэнийг холбон зуучилсан. Нийтийг хамарсан ажил сэг зэм цэвэрлэх 2, мод тарих 4, | 2024.01.01 2024.11.25 | 100 |

182

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | улирлын чанартай ажилд “Өв гурван лут” компаний барилгын ажилд өрөгч 4, цахилгаанчин 1 ногоо суулгах 3 хамруулан ажиллав. “Нэг өрх-нэг ажилын байр хөтөлбөрт хамрагддаг 24 өрх бүх арга хэмжээнд идэвх оролцоотой оролцдог. Өрхүүдийг холбогдох газар нь холбон зуучлан ажиллаж байна.Түр ажилд 10, байнгын ажилд 2 иргэн нийт 12 иргэн зуучлан ажиллаж байна. | | |
| | | Төсөл хөтөлбөрт хамруулсан иргэний хувиар | | | Жилийн эцсийн байдлаар түр ажлын байранд 24 иргэн зуучилсан. Үүнд мод тарих 4, сэг зэмийн устгалд 2, барилгын туслах 5, барилгын армотур 3, ногоо суулгах 3, хог цэвэрлэгээнд 7 иргэн гэх мэт зуучлан оруулсан. Холбон зуучилсан нийт 5 төслийг дэмжүүлж, төсөлд бүрэн хамруулсан. | 2024.01.01<br>2024.11.25 | 100 |
| **Зорилт 2. “Хууль болон бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах”** | | | | | | | |
| 2. | **2.1.** Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилж, хэрэгжилтийг ханган ажиллах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 100 | 100 | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 1-р улиралдаа шинэчлэн батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2024.03.28-ны өдөр Засгийн газрын 2017 оны 67, 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журамд зааснаар 16:00 цагт улс орон даяар гамшгийн зарлан мэдээллийн дуут дохио дуугаргаж, дадлага, сургууль хийгдлээ. 54 иргэн,13 техник хэрэгсэл 3 мотоцикль 5 дугаар сургуулийн гадна талбайд цуглаж багийн ажлын албанд бүртгүүлэн заавар, зөвлөмжийн дагуу гамшгаас хамгаалах дадлага, сургуулилтад хамрагдсан. | 2024.01.01<br>2024.11.25 | 100 |
| | 2.2. Өвөрхангай аймгийн анхан шатны Улаан Загалмай хороотой хамтран ажиллах. | Шинээр сайн дурын идэвхтэн гишүүдүүд элсүүлсэн иргэний тоогоор | 2 | 3 | 2023-2024 оны өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан аймгийн Улаан загалмайн хороотой хамтран зорилтот бүлгийн 7 малчин өрхөд өргөн хэрэглээний хүнсний тусламж үзүүлсэн. Тайлант хугацаанд шинээр сайн дурын идэвхтэн 5 гишүүн элсүүлж, гишүүнчлэлийн татварыг төвлөрүүлж ажиллаж байна. | 2024.01.01<br>2024.11.25 | 100 |
| | **2.3.** Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулж, хамтран ажиллах. | Гэрээний хэрэгжилтийн хувиар | 80 | 80 | Нарны дөш өрхийн эрүүл мэндийн төвтэй 2024 онд хамтран ажиллах гэрээний биелэлт 80 хувьтай хэрэгжиж байна. | 2024.01.01<br>2024.11.25 | 100 |
| | | Үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэний хувиар | 25 | 25 | Нөхөн үржихүйн 15-49 насны эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх эхо үзлэгт 100, умайн хүзүүний эсийн шинжилгээнд 31, хөхний хорт хавдрын эрт илрүүлэгт 85, чихрийн шижин өвчний эрт илрүүлэгт 58, артерийн | 2024.01.01<br>2024.11.25 | 100 |

183

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **гипертензийн эрт илрүүлэгт 86, элэгний хорт хавдрын** илрүүлэг болон В,С вирус 210 иргэн хамрагдсан. 0-5 насны хүүхдийн өндөр, жингийн хэмжилтэд 80 хүүхэд **хамрагдсан.** | | |
| | **2.4.** Мал эмнэлгийн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулах, хамтран ажиллах. | Гэрээний хэрэгжилтийн хувиар | 80 | 80 | Мал эмнэлгийн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Хэрэгжих шатандаа 80 хувьтай байна. | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| | **2.5.** Хагас жил болон жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулж, хуулийн хугацаанд программд оруулах. | Мэдээг мал тооллогын программд алдаагүй үнэн зөв оруулсан хувиар | 100 | 100 | 2024 оны хагас жилийн малын түүвэр тооллогод тус багаас 18 өрх сонгогдож ирсэн бөгөөд тооллогыг журмын дагуу бүрэн зохион байгуулж, хагас жилийн тооллогын маягтад бичилт хийж, мэдээллийг малын программд шивж бүрэн оруулсан. | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| | 2.6. "Багийн хамтарсан баг"-ийн үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөг батлах, удирдлага, арга зүйгээр ханган ажиллах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 90 | 90 | Хамтарсан баг 2024 оны төлөвлөгөө гарган багийн Засаг даргаар батлуулсан. 7 удаа хуралдаж эхний хуралдаанаар төлөвлөгөөг танилцуулж нууцын гэрээ байгуулав. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар "Хүүхэд хамгааллын хамтарсан баг"-ийн 2024 оны ажлын төлөвлөгөөг 6 арга хэмжээний хүрээнд гарган баталсан. Хамтарсан баг 7 удаа хуралдаж эхний хуралдаанаар төлөвлөгөөний танилцуулга хийн нууцын гэрээ байгуулж ажиллаж байна.<br>Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон хүүхдийн утас 108 утсанд хандсан дуудлагын дагуу 11 кейс, илрүүлсэн кейс 8, нийт 19 кейс дээр ажиллаж нөхцөл байдлын үнэлгээ хийн, хүүхдэд эрсдэлийн үнэлгээ хийн ажилласан. Хаасан 19 кейс байна. Эрсдэлтэй 15 айл өрхийн судалгааг гарган, айл өрхөөр явж нөхцөл байдлын үнэлгээ нийн эрсдэлт өндөр хүүхэд, иргэнийг илрүүлэн кейс нээн ажиллаж байна. Эрсдэлт өндөр 9 хүүхдийг эрсдэлийн мэдээллийн санд оруулсан. Хүүхдүүдийг холбогдох байгууллага аж ахуй нэгжид | 2024.01.01 2024.11.25 | 100 |

184

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбон зуучлан ажилласан. | | |
| | **2.7.** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 4 | 4 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг 3 зүйл, 11 арга хэмжээний хүрээнд батлуулан хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор Иргэн таны төлөө аяныг 03 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд зарлан явуулж байна. Аяны хүрээнд багийн Засаг даргын ажлын алба, Хэсгийн байцаагч, Багийн цагдаа нар хамтран Багийн нутаг дэвсгэрт эргүүл хяналтыг тогтмол хийж гүйцэтгэж байна. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн газрын мэргэжилтэн Л.Буяндэлгэртэй хамтран Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай ойлголт, гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, хүлээх хариуцлага, хүүхдийн эрх хамгаалал, мэдээлэх үүрэг хариуцлага сургалтыг эрсдэлтэй 38 иргэнд, Багийн цагдаа н.Эрдэнцогттой хамтран Зөрчлийн тухай хууль, замын хөдөлгөөн дүрэм сургалтыг такси үйлчилгээ эрхэлдэг 45 иргэнд танхимаар зохион байгуулсан. Мөн багийн ажлын албаар үйлчлүүлсэн иргэд болон **Арвайхээр Арваннэгдүгээр баг** фасебүүк аккаунтаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, замын хөдөлгөөний дүрэм, Эрүүгийн тухай хуулийн талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. Хорихоос өөр төрлийн ял, шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд чиглэсэн харилцан мэдээлэл солилцох уулзалтанд 2 иргэнээ хамруулсан. | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| | **2.8.** Хөдөө аж ахуйн ХАА-1, ХАА-2, ХАА-3, ХАА-5, ХАА-6, ХАА-7, ХАА-8, ХАА-9, ХАА-10 мэдээнүүдийг хугацаанд нь үнэн зөв гаргаж, нэгтгүүлэх. | Мэдээний тоо | 47 | 47 | Төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг цаг хугацаанд нь бүрэн өгч, программд шивж оруулсан. Хагас жилийн мал тооллогоор 18 малчин өрх сонгогдож ирсэн цаг хугацаанд нь бүрэн тоолж, шивж оруулсан.Ургацын болон тариалалтын мэдээг цаг хугацаанд нь холбогдох мэргэжилтэнд гарган өгч ажиллаж байна. | 2024.01.01 2024.11.25 | 100 |

185

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **2.9.** Багийн зохион байгуулагч, нийгмийн ажилтныг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах. | Өгсөн үүрэг даалгавар, арга зүйн зөвлөмжийн биелэлтийн хувиар | 90 | 90 | Багийн Засаг дарга нь зохион байгуулагч, нийгмийн ажилтныг өдөр тутмын удирдлагаар хангаж, хувийн зохион байгуулалт, сахилга, дэг журам, ёс зүй, ажлын хариуцлагыг өндөржүүлэн, иргэний хүссэн мэдээлэлд тулгуурлан үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд гол анхаарлаа чиглүүлэн ажиллаж байна | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| | **2.10.** БИНХ-ыг зохион байгуулах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах, биелэлтийг тайлагнах. | Зохион байгуулсан хурлын тоогоор | 4 | 3 | Багийн иргэдийн Нийтийн Хурал 2024 оны эхний 2 улиралд 2 удаа хуралдаж, нийт иргэн 156 иргэн хуралд оролцсон. | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| | | Гарсан шийдвэрийн хэрэгжилтийн хувиар | 90 | 90 | Багийн иргэдийн Нийтийн Хуралдаанаас гарсан 8 тогтоол, 2 хурлын тэмдэглэлийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу хөтөлж хугацаанд нь Арвайхээр сумын ИТХуралд уламжлан хүргэж ажилласан. Мөн 2 хуралдаанаас иргэдээс гаргасан нийт 13 саналыг дээд шатны байгууллагад уламжлан, шийдвэрлүүлж ажиллаж байна. | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| **Зорилт 3. "Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх"** | | | | | | | |
| 3. | **3.1.** Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлэх, удирдлагыг тухай бүр үнэн зөв мэдээллээр хангах. | Үүрэг даалгаврын хэрэгжилт хувиар | 90 | 90 | Байгууллагын шуурхай хурал болон бусад цаг үеийн хуралд тогтмол оролцож, удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, ажиллаж байна. | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| | **3.2.** Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, хариуг өгөх. | Шийдвэрлэлтийн хувиар | 90 | 90 | Нийт 23 өргөдөл гомдол ирснээс алдарт эхийн одонд хамрагдахаар хүсэлт гаргасан өргөдөл 13, хот тохижилттой холбоотой асуудлаар 5 гомдол байна. Өргөдөл гомдлыг ирүүлсэн хэлбэрээр авч үзвэл иргэн өөрийн биеэр ирж өгсөн 26 санал байна. | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| **Зорилт 4. "Төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"** | | | | | | | |
| | **4.1.** Хугацаатай албан бичиг, тайлан мэдээ, судалгааг бүрэн үнэн зөв гаргаж хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэх. | Хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд хүргүүлсэн, хувиар | 100 | 100 | Тус багт 25 албан бичиг ирснээс хугацаатай албан бичиг 13 ирсэн байна. Ирсэн бичигт тусгагдсан 13 судалгаа, 12 тайланг хугацаа хэтрүүлэлгүй бүрэн хүргүүлсэн.. | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| | | Хугацаатай мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлсэн, хувиар | 100 | 100 | Мэдээ тайлангийн графикийн дагуу улсын хэмжээний судалгаа болон албан ёсны статистикийн мэдээ, мэдээллийг холбогдох маягтаар гаргаж, мөн цаг үеийн шаардлагаар нэмэлтээр шаардсан мэдээллийг хугацаанд нь хүргүүлж ажилласан. | 2024.01.01 2024.11.25 | 100 |

186

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **4.2.** Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журам, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, цаг ашиглалт, ажлын бүтээмж, хариуцлагыг дээшлүүлэх. | Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй ажилласан байна. | - | - | Албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаарх мэдлэг, мэдээллээ байнга дээшлүүлж, ашиг сонирхлын зөрчил үүсгэлгүй албан тушаалын чиг үүргээ үнэнч шударгаар биелүүлж, ажиллаж байна.<br>Байгууллагын "Дотоод журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж, ард түмэн, олон нийтэд үйлчлэх явдлыг өөрийн эрхэм үүргээ гэж үзэн хувийн хэрэгт ёс зүйн зөрчлийн тэмдэглэл хийлгэлгүй шударгаар ажиллаж байна. | 2024.01.01<br>2024.11.25 | |
| | | Ажлын цагийн хоцрогдол, ашиглалтын хувиар | 100 | 100 | Ажлын шаардлага болон ачааллаас хамаарч өдөрт 10-аас доошгүй цагаар ажиллаж байгаа бөгөөд хагас жилийн байдлаар 40 гаруй илүү цаг болон шөнийн цагаар ажиллаж, нэг удаа ажил таслаагүй, хоцроогүй байна.<br>Ажлын байранд архи согтууруулах ундаа хэрэглэх зөрчил гаргалгүй, хариуцсан ажлын чиглэлээр аймгийн МШУТөвийн утсаар нэр заасан гомдол гаргалгүй ажиллалаа. | 2024.01.01<br>2024.11.25 | 100 |
| | **4.3.**Хяналт, шинжилгээ үнэлгээний **зөвлөмжийн дагуу** төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 100 | 100 | Хяналт, шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тухайлбал: Төрийн албан хаагчийн хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлсэн, төлөвлөгөө, тайлан мэдээ, албан бичиг боловсруулахад ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Стандарт хэмжилзүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан MNS5140-1:2021 баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллаж байна. Багийн ажлын албаны мэдээллийн самбарын мэдээллийг тогтмол шинэчилж, цахим хуудсаар зар мэдээлэл, эрх зүйн мэдээлэл зэргийг түгээн иргэдийн мэдэх эрхийг хангаж ажиллаж байна. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт 50 хувьтай. | 2024.01.01<br>2024.11.25 | 100 |
| | **4.4.** Байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцох. | Хамрагдсан арга хэмжээний хувиар | 100 | 100 | Байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээ, зохион байгуулалтад идэвхтэй оролцож ажиллалаа. Тухайлбал: Үндэсний бөхийн хүүхдийн улсын аварга шалгаруулах анхдугаар барилдааны зохион байгуулалтад ажилласан. | 2024.01.01<br>2024.11.25 | 100 |
| | **4.5.** Байгууллага, | Арга хэмжээний | 1 | 1 | | 2024.01.01 | 100 |

187

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | багт туршлага болохуйц шинэлэг ажлыг зохион байгуулах. | тоогоор | | | | 2024.11.25 | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин биелэлт | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Монгол хэлний мэдлэг ур чадвараа дээшлүүлэх | Сертификат | Анхан | Дунд | Монгол хэлний ур чадвараа дээшлүүлж, анхан шатны шалгалт өгч тэнцсэн. Монгол хэлний мэдлэг ур чадвараа дээшлүүлэх зорилгоор онлайнаар суралцаж байгаа. | 2024.01.01 2024.11.25 | 100 |
| 2. | Удирдлагын академиас төрийн албан хаагчдад зориулсан танхим болон цахим сургалтанд суралцах | Сертификат | Анхан | Дунд | Удирдлагын академиас төрийн албан хаагчдад зориулсан танхимын сургалтанд хамрагдаж, шилдэг сурагчаар шалгарч, үнэ бүхий зүйлээр шагнуулсан. | 2024.01.01 2024.11.25 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХҮЙС ТОЛГОЙН 11 ДҮГЭЭР БАГИЙН ЗАСАГ ДАРГА .............................. /Б.ЗОЛБОО/

2024.11.25

18